Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а) дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, 2020 оны “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

2. Жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд, мөн 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярын үеэр сумын нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахгүй байхыг уяачдад сурталчилах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нар, “Хужирт ажнай” морин спорт уяачдын холбоо, гишүүдэд, хяналт тавьж ажиллахыг Хүүхэд, Гэр бүл, Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Жавзандолгорт тус тус үүрэг болгосугай.

3. Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл түр зогсоосонтой холбоотойгоор хүүхэд, багачууд, иргэдийн дунд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг Соёлын төвийн эрхлэгч О.Долгормаа, сумын Биеийн тамир спортын арга зүйч Т.Баярцэрэн нарт үүрэг болгосугай.

4. Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Хүнс, Газар тариалан, хоршоо, үйлчилгээний салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Самданд даалгасугай.


5. Улсын Онцгой комиссоос хот хоорондын замын хөдөлгөөнийг түр зогсоох шийдвэр гарсантай холбогдуулан сумаас гарах, орох хөдөлгөөнийг 2020 оны 2 дугаар сарын 23-ны 08⁰⁰ цагаас 2020 оны 2 дугаар сарын 27-ны 08⁰⁰ цаг хүртэл түр зогсоох, арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга Ж.Оюунгэрэл, Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч Х.Түмэнбаяр нарт үүрэг болгосугай.

250100063

6. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг 2020 оны 2 дугаар сарын 22-ны 08⁰⁰ цагаас 2020 оны 2 дугаар сарын 27-ны 08⁰⁰ цаг хүртэл түр зогсоох арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга Д.Мөнхбатад даалгасугай.

7. Дээрх тогтоосон хугацаанд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулсан хувь хүн, уяач, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, хошууч Х.Түмэнбаярт, Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга Д.Мөнхбатад тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/33

Хужирт сум

Корона вирусийн халдвараас урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а), Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар тогтоол, 07 дугаар хуралдааны тэмдэглэлийн 9 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн зорчигч тээвэр, аймаг, сум, баг хоорондын хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08⁰⁰ цагаас 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 08⁰⁰ цаг хүртэл сунгасугай.

2. Шашны байгууллагын шашин номын хурал, цуглаан зохион байгуулах, зан үйлд олон нийтийг оролцуулах, уул овоо тахих зэрэг үйл ажиллагааг түр хориглосугай.

3. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг түр зогсоох хугацааг 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 08⁰⁰ цагаас 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 08⁰⁰ цаг хүртэл сунгасугай.

4. Байгууллагын ажилтан, албан хаагчдыг дайчлан сумын төвийн хяналтын 6 цэгт ажиллах эргүүлийн хуваарийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Ж.Оюунгэрэл), Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100065



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/34

Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжөөр Эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах "ӨВАХУСЗДТГ202001008" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт шаардлагад нийцсэн үнийн санал ирүүлээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (О.Алтанчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/35

Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар зөвлөмжөөр Эрүүл мэндийн төвийн эмчилгээний хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах "ӨВАХУСЗДТГ202001009" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Ж.Шижээ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/36

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн дагуу 3 дугаар Цэцэрлэгийн Хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 45234200 (дөчин таван сая хоёр зуун дөчин хоёр мянга) төгрөгөөр “Дэлгэрэх Хужирт” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Д.Норов)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг 3 дугаар Цэцэрлэг хариуцсан нягтлан бодогч (Л.Сувд-эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/37

Хужирт сум


Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 14/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5 дугаар багийн нутаг төвийн гүүрнээс хойш голын зүүн эрэг дагуу байрлах 25000 м² газрыг “Хужирт эрдэс баялаг” ОНӨААТҮГ (3564428)-т Шаврын орд бүхий газрын ашиглалт, хамгаалалтын зориулалтаар (30жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/38

Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Засаг даргын Тамгын газарт шатах, тослох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах "ӨВАХУСЗДТГ202001006" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100075



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/39

Хужирт сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1, 32 дугаар зүйлийн 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/90 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

3. Шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах, ажилтан, албан хаагчдын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар ариутгах, халдваргүйжүүлэх, нөөцийг бүрдүүлж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг төрийн байгууллагын болон аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” А/30 дугаар захирамжийн 3 дахь заалтын баар, кароке, цэнгээний газар гэсний ард “цахим тоглоомын газар, спорт заал” гэж нэмсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжүүлэн ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл), Цагдаагийн тасгийн дарга, хошууч (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

250100079



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/04

Хужирт сум

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” тогтоолын 1, 4, 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Соёлын төвийн дарга Ойдовын Долгормаагийн албан тушаалын цалинг ТҮСУ 5-5 шатлал буюу 895945 (найман зуун ерэн таван мянга есөн зуун дөчин тав) төгрөгөөр шинэчлэн баталсугай.

2. О.Долгормаагийн албан тушаалын цалин, удаан жилийн нэмдэгдлийг үндсэн цалингийн 25, ур чадварын нэмэгдлийг 25, орон нутгийн нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн Соёлын төвийн цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Ч.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/20

Хужирт сум

Коронавируст халдвар (COVID-19)-ын
үед нэмэлтээр ор дэлгэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглал, батлах туай” А/101 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх тухай” А/75 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавируст халдвар (COVID-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх төлөвлөлтийг нэгдүгээр, голмтонд ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны нэрсийн жагсаалтыг хоёрдугаар, хавьтагсдын тусгаарлах байр, ажиллах эмч, мэргэжилтнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэмэлтээр ажиллах тасаг, нэгжийг бэлтгэн, дайчлан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг сургаж дадлагажуулах, шаардлагатай эм, эмнэлэгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хоол хүнсний бэлэн байдлыг хангаж нөөцийг бүрдүүлэхийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ц.Ундрахбаяр), рашаан сувиллуудын дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/Н1

Хужирт сум

「Шинэ коронавируст (COVID-19) халдвараас
урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а), Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн (COVID-19)-ын халдвар Монгол Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн зорчигч тээвэр, аймаг, сум, баг хоорондын хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 07⁰⁰ цагаас 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 07⁰⁰ цаг хүртэл зогсоосугай.
2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс 3 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.
3. Онцгой комиссын хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, сумын төвийн 5 цэгт ажиллах хяналтыг постын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Сумын Онцгой комиссын 70325850 дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг тухай бүрт өгч ажиллахыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захирал, эрхлэгч нарт даалгасугай.
5. Шаардлагатай зардлыг гүйцэтгэлээр тооцож, санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.
6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Ж.Оюунгэрэл), Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100081



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/42

Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 10-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжөөр Эрүүл мэндийн төвийн эмчилгээний хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах "ӨВАХУСЗДТГ202001009" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/143

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу 2 дугаар Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-1 Гурил, гурилан бүтээгдэхүүн багцыг 10599000 (арван сая таван зуун ерэн ес) төгрөгөөр, багц-3 Хүнсний ногоо багцыг 11100000 (арван нэгэн сая нэг зуун мянга) төгрөгөөр, багц-4 Мах махан бүтээгдэхүүн багцыг 38950000 (гучин найман сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр, багц-5 бусад бүтээгдэхүүн багцыг 15766200 (арван таван сая долоон зуун жаран зургаан мянга хоёр зуу) төгрөгөөр “Дэлгэрэх Хужирт” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Ш.Эрдэнэхорол)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг 2 дугаар Цэцэрлэг хариуцсан нягтлан бодогч (Л.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй багц-2 Сүү, сүүн бүтээгдэхүүн багцыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцыг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (А.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100085



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/44

Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжөөр 1 дүгээр Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах "ӨВАХУСЗДТГ202001001" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100087



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 1/45

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 18406600 (арван найман сая дөрвөн зуун зургаан мянга зургаан зуун) төгрөгөөр “Шунхлай Трейдинг” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Ц.Ундрахбаяр)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч (Н.Ганчөдөр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 9/46

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 111489860 (нэг зуун арван нэгэн сая дөрвөн зуун наян есөн мянга найм зуун жаран) төгрөгөөр “Буман сувд” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Гантулга)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Ч.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100091



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/47

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу Засаг даргын Тамгын газарт шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 14148950 (арван дөрвөн сая нэг зуун дөчин найман мянга есөн зуун тавин) төгрөгөөр “Шунхлай Трейдинг” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100093



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/48

Хужирт сум

Газар зүйн нэрийн салбар
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2, 5.8.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 зарлиг, Аймгийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах, газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах, шинээр өгөх болон өөрчлөх газар зүйн нэрийг хэлэлцэн “Аймгийн газар зүйн нэрийн салбар зөвлөл”-д хүргүүлэхийг сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ц.Нямдорж)-д даалгасугай.

3. Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулах, дээрх ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт суулгах, тухай бүрд шийдвэрлэн ажиллахыг санхүүгийн албаны дарга (Д.Уранчимэг), салбар зөвлөлийн дарга (Д.Мөнхбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар
сарын 12-ны өдрийн 448 дугаар
захирамжийн хавсралт

“ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга: Д.Мөнхбат-Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдорж-Газрын даамал

Гишүүд: Д.Уранчимэг-Санхүүгийн албаны дарга

З.Цэцэгмаа-Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

С.Самдан-Бэлчээр, худаг ус хариуцсан мэргэжилтэн

Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян-2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом-5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга

Э.Бямбацэрэн- Хэсгийн төлөөлөгч

Л.Шарав- 1 дүгээр багийн иргэний төлөөлөл

Н.Бат-Очир-2 дугаар багийн иргэний төлөөлөл

Б.Цэргүүш-3 дугаар багийн иргэний төлөөлөл

Ц.Жалхаажав-4 дүгээр багийн иргэний төлөөлөл

Б.Санжаазав-5 дугаар багийн иргэний төлөөлөл

Г.Дамчаабадгар-6 дугаар багийн иргэний төлөөлөл

Х.Ойдов-2 дугаар багийн Өв хамгаалагч



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/49

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 14/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн нутаг, иргэн Н.Батзаяагийн эзэмшлийн газрын баруун талд байрлах 400 м² газрыг Хужирт рашаан сувилал” ХХК (РД:3551156)-нд цэвэрлэх байгууламж барих зориулалтаар (15 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Захирамж гарсанаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг “Хужирт рашаан сувилал” ХХК-ний гүйцэтгэх захирал Г.Энхжаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/05

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай, Хужирт 5 дугаар баг Шунхлайн 2 тоот хаягт байрлах Хужирт сумын Засаг даргын Тамгын газар (9045562) нь өөрийн эзэмшлийн 5 дугаар баг Гуа 3-6 тоотод байрлах 000004477 тоот гэрчилгээний дугаартай, 6211003870 тоот нэгж талбарын дугаартай "Боловсролын байгууллага"-ын зориулалттай 2300.0 м² газрыг Хужирт 5 дугаар баг, Гуа 3-6 тоот хаягт байрлах Хужирт сумын гуравдугаар Цэцэрлэг (3566684) -ийн эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Хужирт сумын гуравдугаар Цэцэрлэг (3566684)-т "Боловсролын байгууллага"-ын зориулалтаар 58 жил 11 сарын хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бэртгэхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/182 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/50

Хужирт сум


Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 128,082.100 (нэг зуун хорин найман мянга нэг зуун) төгрөгөөр “Дэлгэрэх Хужирт” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Т.БАЯРМӨНХ



250100099



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/51

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр баг, Шивээт 10-4 тоот хаягт байрлах Лэгшидийн Зориг (ЙС72062231) нь өөрийн эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 33 тоотод байрлах 000004871 тоот гэрчилгээний дугаартай, 6211003857 тоот нэгж талбарын дугаартай “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор”-ын зориулалттай 15437.0 м² газраас 10000 м² газрыг Улаанбаатар, Чингэлтэй, 4 дүгээр хороо, Бага тойруу, 11-54 тоот хаягт байрлах “Бизимэн групп” ХХК (5269458)-ийн эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг “Бизимэн групп” ХХК (5269458)-д “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор”-ын зориулалтаар 2 жил 8 сарын хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/175 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 27 өдөр

Дугаар A/52

Хужирт сум

Асран хамгаалагч, харгалзан
дэмжигчээр томилох тухай

Гэр бүлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, 64 дүгээр зүйлийн 64.1.1 67 дугаар зүйлийн 67.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн Бямбажавын Лхагвамаа (ЙС09251301) охины асран хамгаалагчаар, Отгончимэгийн Цэнд-очир (ЙС06222415) хүүгийн харгалзан дэмжигчээр түүний ээжийн төрсөн эгч тус сумын Өвөрмодот 1 дүгээр багийн иргэн Цагаалайн Эрдэнэцэцэгийг (ЙС60011721) томилсугай.

2. Холбогдох баримт бичгийг бүрдэл болгож тэтгэмжинд хамруулахыг Нийгмийн даатгалын тасгийн дарга (Ч.Байгальмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 4/53

Хужирт сум

Сумын тухайн жилийн газар зохион
байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1 дэх заалт, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2010 оны 497 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. 2021 онд сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх асуудлаар төлөвлөгөөний төслийг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Ц.Нямдорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100105

Сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар
сарын 23-ны өдрийн 453 дугаар
захирамжийн хавсралт

Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний
төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Салбар зөвлөлийн дарга: Ж.Оюунгэрэл-сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдорж-Газрын даамал

Гишүүд: З.Цэцэгмаа-Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

С.Самдан-Бэлчээр, худаг ус хариуцсан мэргэжилтэн

Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян-2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом-5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга

Ц.Тунгалаг-Цаг уурын өртөөний эрхлэгч



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/54

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 14/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шунхлай 5 дугаар багийн нутаг Жамбалын талд байрлах 5,0 га газрыг 5 дугаар багийн иргэн Б.Рэгэнбадам (ИС78042238)-д төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар 30 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/55

Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу “Хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх дэлгүүр сонгох” тендерийг 147000.000 (нэг зуун дөчин долоон сая) төгрөгөөр “Дэлгэрэх Хужирт” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг сум хариуцсан мэргэжилтэн (Ё.Даариймаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/06

Хужирт сум

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хужирт эрдэс баялаг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Жигжидийн Шижээгийн албан тушаалын цалинг ТҮ-9-1 шатлал буюу 784647 (долоон зуун наян дөрвөн мянга зургаан зуун дөчин долоо) төгрөгөөр тооцож шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэгдсэн цалинг 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн “Хужирт эрдэс баялаг” ОНӨААТҮГазрын цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Н.Ганчөдөр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/07

Хужирт сум


Агаарын бохирдолын эх үүсвэрийн
2020 оны тооллогын ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (г), Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.14, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2018 оны "Журам батлах тухай" А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн 2020 оны ээлжит тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Ээлжит тооллогын бэлтгэл ажлыг ханган, тооллогыг 2020 оны 1 дүгээр сарын 21-30-ны өдрүүдэд чанартай зохион байгуулж, тооллогын нөхөгдсөн асуулгын хуудас, урьдчилсан дүн, бусад материал зэргийг тогтоосон хугацаанд багтаан аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлийн хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ж.Оюунгэрэл), Нарийн бичгийн дарга (О.Алтанчимэг), Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 20²⁰ оны 01 дүгээр
сарын 21 -ны өдрийн 4/07 дугаар
захирамжийн хавсралт

Сумын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Оюунгэрэл - Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: О.Алтанчимэг - Байгаль хамгаалагч

Гишүүд: З.Цэцэгмаа Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Х.Түмэнбаяр Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Ч.Сонинбаяр-Байгаль хамгаалагч

Л.Батбилэг-Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Ц.Нямдорж-Газрын даамал

Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян – 2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга

Я.Осоржамаа –5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/08

Хужирт сум

“Хүүхдээ сонсох өдөр” болгох
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.4.1, 16.4.2 дахь заалт, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны “Хүүхдээ сонсох өдөр”-ийг тогтоох тухай” 03 дугаар тогтоолыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар бүрийн эхний долоо хоногийн 1 дэх өдрийг “Хүүхдээ сонсох өдөр” болгосугай.

2. “Хүүхдээ сонсох өдөр”-ийг хүүхдүүдтэй хамтран хэрэгжүүлэх байгууллагуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

3. “Хүүхдээ сонсох өдөр”-ийн төлөвлөгөө боловсруулан баталж хүүхдийн санал бодлыг сонсох, санал хүсэлтийг хүлээн авч, хүүхдэд ээлтэйгээр шийдвэрлэн ажиллаж, төлөвлөгөөний тайланг сар бүрийн 25-ны өдөр зургаар баримтжуулан сумын Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэнд ирүүлж байхыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тайланг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хүралд хагас, бүтэн жилээр тайлагнаж байхыг Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Жавзандолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 4/09

Хужирт сум

Цалин шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Цогтбаярын Ундрахбаярын албан тушаалын цалинг ТҮЭМ-5-1 шатлал буюу 731369 (долоон зуун гучин нэгэн мянга гурван зуун жаран есөн) төгрөгөөр шинэчлэн баталсугай.

2. Ц.Ундрахбаярын орон нутгийн нэмэгдлийг 20 хувь, түр орлон гүйцэтгэсний нэмэгдлийг 20 хувиар тус тус тооцож шинэчлэгдсэн цалинг 2020 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн Эрүүл мэндийн төвийн цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Н.Ганчөдөр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ